

НИЙСЛЭЛИЙН ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2015 ОНЫ ГАДААД АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар нь Засгийн газрын 2013 оны 196 дугаар тогтоолоор баталсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам” Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/153 захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын гадаад харилцааны үйл ажиллагааны журам”-ыг гадаад арга хэмжээнд мөрдөн ажиллалаа.

2015 онд дараах гадаад арга хэмжээнд оролцлоо. Үүнд:

Бүгд найрамдах Солонгос Улсын ЁЖҮ хотод 2015 оны 1 дүгээр сарын 19-24-ний өдрүүдэд Технологийн дээд сургуулиас зохион байгуулсан “Хотын хөгжил ба төлөвлөлт” сэдэвт сургалтанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба болон Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн нэр бүхий 15 албан хаагчид хамрагдлаа. Үүнд тус газраас захиргааны хэлтсийн дарга Д.Мягмарсүрэн төлөөлөн оролцов. Уг сургалтаар дараах байгууллага, бүтээн байгуулалтын төсөлтэй танилцав.

- Солонгосын Хан мөрөн дээр хэрэгжүүлсэн “Дөрвөн голын төсөл”-ийн үйл ажиллагаа
- “Шинэ тосгон хөдөлгөөн”-ий үйл ажиллагаа
- Иргэдэд үйлчлэх төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн Сөүл хотын “Дасан колл центр”-ын үйл ажиллагаа



Бүгд найрамдах Австри улсын Вена хотод 2015 оны 06 сарын 11-17 өдрүүдэд “Нийслэлийн бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төслийн хүрээнд Нийслэлийн үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын дарга Г.Пүрэвсүрэн, газар тариалангийн хэлтсийн дарга Ц.Төмөртулга нар томилолтоор ажиллав.

2014 оны 06 сар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Вена хотод хийсэн албан айлчлал хүрээнд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн үр дүнг хэлэлцэж, дараах ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлсэн. Үүнд

- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 121 тоот тогтоолоор “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар байгуулагдсан.
- Нийслэлийн Засаг даргын А/631 тоот захирамжаар Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжих “Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих”

хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг боловсруулахаар тохиролцсон.

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай техник тоног төхөөрөмж, үр бордоо, дэд бүтэц, барилга байгууламжийн сонголтыг хийж худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулсан.



Хятад улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөх хотод 2015 оны 03 сарын 28-ны өдрөөс 04 сарын 03 өдрүүдэд “Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ эмийн ургамал, мөөг, цэцгийн аж ахуй, байгаль орчин, ногоон байгууламжийг хөгжүүлэх, 2 талын хамтын ажиллагааг эрчимжүүлэх замаар харилцан хөгжил дэвшилд хүрэх чиглэлээр үр дүнтэй ажиллах, туршлага судлах, санамж бичгийн төслийг танилцуулах” чиглэлээр газар тариалангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ч.Авирмэд, У.Өнөржаргал, С.Гочоосүрэн, Д.Зандармаа, мөн “Фермер эмэгтэйчүүдийн холбоо”, “Ногоон говь тал” нийгэмлэг, “Тэгш мөр” төрийн бус байгууллагын удирдлагуудтай туршлага солилцсон.

Уг ажлын хүрээнд Хөх хотын цэцэрлэгжилтийн хүрээлэнгийн мод үржүүлэг, мөөг, гуатан ургамал, цэцэг, үрийн аж ахуйн секторын ахлагч дарга, эрхлэгч нартай албан ёсны уулзалтыг зохион байгуулсан. Мөөгний аж ахуйн хөрс боловсруулалт, тариалалт, хураалт борлуулалтын маркетинг, менежментийг судалж, цаашид мөөгний аж ахуйг хөгжүүлэх зорилгоор мөөгний 2 төрлийн өсгөврийг авчран “Ногоон говь тал нийгэмлэг” ТББ-ийн хүлэмжинд үржүүлж, өнөөдрийн байдлаар өсгөврийг Монгол орны цаг уурын нөхцөлд ургуулан эхний ургацаа хураан авлаа. Хүрээлэнгийн 4 секторын эрхлэгчид монгол орны хөрс цаг уурын нөхцөлд дасан зохицох чадвартай ашигт таримлууд, гуатан ургамлын судалгааг хамтран хийх саналыг дэвшүүлсэн. Түүнчлэн цаашид хамтран ажиллах санамж бичгийн төслийг боловсруулсан. Мөн ногооны үрийн аж ахуйн шинэчлэл, чанар, сорт, үнийн судалгааг хийгдэж байна.



Бүгд найрамдах Хятад ард улсын Шэнси мужийн Янлин хотод 2015 оны 05-р сарын 15-ны өдрөөс 06 сарын 04 хүртэл “Шанхайн хамтын ажиллагааны орнуудын хөдөө аж ахуйн удирдлага” сэдэвт 21 хоногийн сургалтанд газар тариалангийн хэлтсийн мэргэжилтэн Ч.Авирмэд хамрагдсан.

Уг сургалтанд Шанхайн хамтын ажиллагааны гишүүн-11 орон, ажиглагч-4 орны нийт 40 төлөөлөгч оролцлоо. Хятад улсын хөдөө аж ахуйн өнөөгийн байдал, дэвшилтэт шинэ технологийг өөрийн хөдөө аж ахуйн салбарт хэрхэн ашиглаж өндөр үр дүнд хүрч байгааг газар дээр нь үзэж танилцсан. Цаашид хөдөө аж ахуйг олон улсын жишигт нийцүүлэн шинэ удирдлага менежментээр хангаж ажиллах, шинэ таримлуудыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, цоо шинээр тухайн салбарт орж ирж буй цэцгийн аж ахуйн хөгжил, ашигт таримлын үйлдвэрлэлийн шинэ таримлуудын тариалалттай танилцаж, хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдыг хэрхэн төр засгаас санхүү эдийн засгийн дэмжлэг үзүүлэн цаашид тариалах талбайн хэмжээг нэмэгдүүлэх, тэдэнд хөнгөлөлттэй нөхцлөөр хамгийн сүүлийн үеийн хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмжийг олгодог зэрэг Хятад улсын өнөөгийн амжилтанд хүрсэн талаарх мэдээ мэдээллийг онолын болон дадлагын хэлбэрээр суралсан.



Бүгд найрамдах Хятад ард улсын Бээжин хот, Гуанши муж Наннин хот, Гуандун муж Гуанжу хотуудад 2015 оны 09 сарын 08 аас 10 сарын 01-ний өдрүүдэд “Хөдөө аж ахуйн бодлого, хөгжил ба хөгжиж буй орнууд” сэдэвт 21 хоногийн сургалтанд газар тариалангийн хэлтсийн мэргэжилтэн Х.Эрбол, эрчимжсэн мал аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн Ц.Ариунзул нар хамрагдсан.

Сургалтын үйл ажиллагааг FECC /БНХАУ-ын ХААЯам-ны харьяа Гадаадын эдийн засгийн хамтын ажиллагааны төв/-ийн ерөнхий захирал Ху Юан Ан нээж, сургалтанд оролцогсдод амжилт хүсч, цаашдын хамтын ажиллагааг улам

өргөжүүлэхийг хүсч буйгаа илэрхийлсэн. Сургалтанд нийт 25 орны 65 хүн хамрагдсан.

2015 оны 09-р сарын 09-ний өдрөөс 2015 оны 09-р сарын 18-ны өдөр хүртэлх хугацаанд БНХАУ-ын Бээжин хотод “Хүнсний аюулгүй байдал”, “БНХАУ-ын ХАА-н хөгжил”, “Орчин үеийн судалгааны арга зүй”, “ХАА-н гаралтай бүтээгдэхүүний чанар”, “БНХАУ-ын орчин үеийн загасны аж ахуй”, “Хүнсний ногооны тариалалт” зэрэг лекц, семинарт хамрагдсан.

2015 оны 09-р сарын 19-нөөс 2015 оны 09-р сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд Хятадын Наннин, Гуанжу, Жухай зэрэг хотуудын хөдөө аж ахуй, хүнс үйлдвэрлэдэг жижиг дунд үйлдвэр, цэцгийн лаборатори, загасны аж ахуй зэрэг семинарт дурдагдсан газруудаар явж, үйл ажиллагаатай биечлэн танилцсан.

2015 оны 09-р сарын 28-ны өдөр сургалтын хаалтын үйл ажиллагаа болж, сургалтанд оролцогсдод БНХАУ-ын ХААЯам-ны БНХАУ-ын ХААЯам-ны харьяа Гадаадын эдийн засгийн хамтын ажиллагааны төвийн ахлах Ли Жа Ли сертификат гардуулж, сургалт өндөрлөсөн.

Тус сургалтанд хамрагдсанаар БНХАУ-ын ХАА-н орчин үеийн техник, технологийн хөгжил, ХАА-н гаралтай хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл зэргийн талаарх мэдлэгээ дээшлүүлээ



Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөх хотод 2015 оны 10 сарын 20-27 өдрүүдэд “Монгол Хятадын Экспо” анхдугаар үзэсгэлэнгийн арга хэмжээнд Захиргааны хэлтсийн дарга Д.Мягмарсүрэн, Эрчимжсэн мал аж ахуйн хэлтсийн дарга Т.Дэлгэрсайхан нар амжилттай оролцов.

Уг арга хэмжээний үеээр Нийслэлийн ИТХ-ын даргын илгээлтийг Хөх хотын засаг захиргаанд хүлээлгэн өгсөн. 2 орны хамтын үйл ажиллагааг хөгжүүлэх, бизнес, худалдаа, хөдөө аж ахуйн чиглэлээр хамтран ажиллах боломжийг судалсан.



Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Япон улсын Цукуба Их сургуулийн хооронд 2014 оны 10 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан санамж бичгийн хүрээнд тус сургуулиас зохион байгуулсан “Хүрээлэн буй орчны шинжлэх ухааны тогтвортой хөгжил” сэдэвт богино хугацааны сургалтанд 2015 оны 10-р сарын 12-24 өдрүүдэд үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн Ц.Төмөрбаатар, захиргааны хэлтсийн мэргэжилтэн Г.Болор-Эрдэнэ нар хамрагдав.



Япон улсын Хоккайдо хотод 2015 оны 08-р сарын 18-ны өдрөөс 08 сарын 29 хүртэл “Жайка” олон улсын байгууллага, Япон улсын “Хоккайдо” мужийн “Сорачи Экологи түгээн нэвтрүүлэх орчин бий болгох зөвлөл, Хоккайдо хотын Нэгдсэн эрдэм шинжилгээний хүрээлэн, Техникийн их сургуулийн хамтарсан Сэргээгдэх эрчим хүч буюу “Газрын хөрсний дулаан ашиглан хүлэмжний ногоо тариалах, шилжүүлэх” төслийн хүрээнд агрономичдыг дадлагажуулах” сэдэвт 10 хоногийн сургалтанд газар тариалангийн хэлтсийн мэргэжилтэн Ч.Авирмэд, С.Гочоосүрэн нар хамрагдав.

Уг сургалтанд Хоккайдо хотын Техникийн их сургуулийн Хөдөө аж ахуйн сургуулийн туршилтийн талбай, Ивамизава хотын ахлах сургуулийн талбайд онол, дадлагыг 10 хоног хиисэн. Мөн хүлэмж, цэцэг, үр, жимсний аж ахуйн талба дээр ажилласан. Сургалтын гол үр дүн нь Япон улсын газар тариаланд ашиглагдаж байгаа жижиг оврын хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмжийг өрхийн аж ахуйн хэрхэн ашиглаж га –с авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх, ургамал хамгааллыг химийн бус аргаар яаж хийдэг, өрхийн аж ахуйн үйлдвэрлэлийн борлуулалтыг төр засгаас болон хоршоо төрийн бус байгууллагууд яаж зохицуулж газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж байгааг газар дээр нь үзэж тухайн төслийг өрхийн аж ахуйд хэрхэн хэрэглэж үр дүнд хүрсэнтэй танилцлаа. Япон улс үр үйлдвэрлэлийг газар тариалангийн гол цөм болгон тухайн орон нутагтаа ургац арвин өгөх сортыг сонгон тариалалт хийдэг онцлогтой танилцлаа. Хүлэмжийн аж ахуйн хөгжлийн онцлог нь ургалт хурдан өвчин хортонд тэсвэртэй сортын ургамал дээр залгаадсыг маш чадварлаг хийж арвин ургац авдаг туршлагыг судалж өөрсдийн гараар залгаадас хийж үзсэн нь цаашид өөрийн орны нөхцөлд хийх бололцоотой болсон. Японы хөдөө аж ахуйн ахлах сургуулиас ХАА-н боловсон хүчнийг насан туршийн хөдөлмөр хийх хэмжээнд чадварлаг мэргэжилтэн болгон бэлтгэдэг нь тус салбарын хөгжлийн гол тулгуур болдог нь харагдаж байна.

Хүнсний хангамж гол нэрийн бүтээгдэхүүний эрүүл ахуй хадгалалт, борлуулалтанд мөрддөг стандарт нь бүр хэвшмэл арга ажиллагаа болсныг мэдэж авсан. Тухайн төсөл хэрэгжсэнээр Монгол орны цаг уурын нөхцөлтэй ижил төстэй Хоккайдо мужид экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнийг жилийн 4 улиралд газрын доорх дулааныг ашигласан хүлэмжинд үйлдвэрлэн ургуулж иргэдийнхээ хүнсний хангамжийг шинэ ногоогоор хангадаг туршлага нэвтэрч, өнөөдрийн байдлаар Сонгинохайрхан дүүргийн 21-р хороонд 144м2

нийлэг 3 давхар хальсан газрын доорх дулааныг ашиглах төхөөрөмжийг суурилуулан барьсан хүлэмжинд 6 удаагийн давталттай навчит ногоог тарьж ургуулан ургацаа хураан авч авлаа.Энэ нь цаашид жилийн 4 улиралд хүлэмжинд тариалалтыг хийж, бүрэн ашиглах боломжийг бүрдүүлж байна.



НИЙСЛЭЛИЙН ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР